



Тодруулгын хариу

Тендерийн нэр	Даатгалын үйлчилгээ үзүүлэгчийг сонгох
Тендерийн дугаар	ЭТТХК/20240103236
Тендер зарласан огноо	2024 оны 09 дүгээр сарын 04
Тендер нээх огноо	2024 оны 09 дүгээр сарын 27
<b>Тодруулга №1</b>	
<b>Тодруулга</b>	<b>Хариу</b>
Бид та бүхний зарласан тендерт оролцохоор ажиллаж байгаа билээ.Тус тендертэй холбоотой Өмнөх жилүүдийн хохирлын түүх /Нөхөн төлбөрийн мэдээлэл/-ийг бидэнд илгээж өгөхийг хүсэж байна.	<ul style="list-style-type: none"> <li>- Эд хөрөнгийн даатгалын хувьд өнгөрсөн жил нөхөн төлбөрийн 1 тохиолдол гарч хариуцагч даатгалын компаниар 1,595,000₮ нөхөн төлбөр шийдвэрлүүлсэн.</li> <li>- Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын хувьд өнгөрсөн жил нөхөн төлбөрийн 1 тохиолдол гарч, даатгагч 545,000₮ нөхөн төлбөр шийдвэрлэсэн.</li> </ul>
<b>Тодруулга №2</b>	
<b>Тодруулга</b>	<b>Хариу</b>
Эд хөрөнгийн даатгал дээр дараах асуулгын дагуу жагсаалтыг бэлтгэн ирүүлнэ үү. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>- Одоо байгаа эд хөрөнгийн хувьд</li> </ul> Эд хөрөнгийн нэр, марк, тоо хэмжээ, үнэлгээ зэрэг мэдээлэл бүхий жагсаалт <ul style="list-style-type: none"> <li>- Шинээр худалдан авалт хийх эд хөрөнгийн хувьд</li> </ul> Эд хөрөнгийн худалдан авалт хийхээр төлөвлөсөн тоо бүртгэл	<ul style="list-style-type: none"> <li>- Компанид одоо ашиглагдаж байгаа хөрөнгийн нэр, тоо хэмжээ, үнэлгээг хавсралтаар хүргүүлж байна.</li> <li>- Шинээр худалдан авах хөрөнгийн хувьд захиалгын хуудсанд барилга байгууламж, тавилга эд хогшил, тоног төхөөрөмж, компьютер тоног төхөөрөмж, бусад хөрөнгө гэж 5 бүлэгт хуваан нийт 928,248,318 ₮ үнэлгээг оруулсан болно.</li> <li>- Компани нь 2024-2025 онд шинээр худалдан авах хөрөнгийг худалдан авч, үндсэн хөрөнгөд бүртгэсний дараа хураамжийг гүйцэтгэлээр төлнө. Тодруулбал, 2024-2025 онд нэмэгдэх хөрөнгийг худалдан аваагүй тохиолдолд хураамжийг төлөхгүй.</li> </ul>
ТШЗ 19.2-т Техникийн чадавхи болон туршлагын шаардлагыг нотлох баримт бичгийн 2-т ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагыг нотлох гэрээний дэлгэрэнгүй мэдээллийг ирүүлэхийг шаардсан байна. Манай компани ижил төстэй гэрээний шаардлагыг хангаж байгаа боловч тухайн харилцагчтай байгуулсан нууцын гэрээгээр харилцагчийн нэрийг дурдсан бүхий л мэдээллийг ил болгохгүй үүрэг хүлээсэн болно. Тиймээс бид бусад харилцагчийн гэрээний мэдээллийг бусад хэлбэрээр баталгаажуулж болох эсэхийг тодруулж өгнө үү.	<ul style="list-style-type: none"> <li>- Тендерт оролцогч нь Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь файл үүсгэн ирүүлнэ.</li> <li>Тус файлын эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн эрх бүхий этгээд баталгаажуулан ирүүлнэ.</li> <li>Тендерт оролцогч хуульд заасан үндэслэлээр нууцалж буй баримт бичиг, мэдээлэл бүрд хамаарах хууль зүйн үндэслэлийг тодорхой тайлбарласан тайлбарыг V бүлгийн Маягт 12-ын дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.</li> <li>Бүх материалыг нууцалж ирүүлсэн тохиолдолд татгалзах үндэслэл болно.</li> </ul>